


ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

08.03 - 08.07



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа. Технологийн компаниудыг илүүтэйгээр агуулдаг Nasdaq Composite индекс түүхэн дээд хэмжээндээ хүрсэн бол S&P 500 индекс энэ оны 2-р сарын дээд түвшнээсээ 1.2% орчим мужид орсон байна. Агаарын тээврийн салбарт туслалцаа үзүүлэх найдлагаар аж үйлдвэрлэлийн салбар хамгийн их өсөлт үзүүлсэн бол эрүүл мэндийн салбар бууралттай байлаа. Refinitiv агентлагын мэдээлснээр S&P 500 индексийн 132 компани 2-р улирлын орлогын тайлангаа энэ долоо хоногт гаргахаар төлөвлөсөн байна.

Хэдийгээр долоо хоногийн турш индексүүд өсөлттэй байсан ч, өсөлтийн шалтгааныг тодорхойлох нь энэ удаад харьцангуй хүндрэлтэй байсан бөгөөд, сүүлийн саруудтай харьцуулахад арилжааны хэмжээ бага байжээ. Энэ долоо хоногт эдийн засгийн үзүүлэлтүүд нийтлэгдсэн нь зах зээлд эерэгээр нөлөөлсөн байх магадлалтай. 7-р сарын үйлдвэрийн захиалга таамаглалаас ихээр нэмэгдэж, ISM индекс 2019 оны эхэн үеэс хойших дээд хэмжээндээ хүрснээр үйлдвэрлэлийн үзүүлэлтүүд эерэг хүлээлттэй байна. Тус индексийн үйлчилгээний салбарын өсөлт ч мөн таамаглалаас их байжээ.

Европ: Европт эдийн засгийн тэлэлт ажиглагдаж байгаагаас гадна, АНУ-ын нэмж эдийн засгийг идэвхжүүлэх арга хэмжээ авах найдвар байгаатай холбоотой энэ долоо хоногт Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа. Гэхдээ, АНУ болон БНХАУ-ын хурцадмал нөхцөл байдал, түүнчлэн коронавирусын тохиолдол дахин нэмэгдэж байгаа нь хөрөнгийн зах зээлийн өсөлтийг хязгаарласан байна. STOXX Europe 600 индекс 2.03%-аар, DAX индекс 2.94%-аар, CAC 40 индекс 2.21%-аар, FTSE MIB индекс 2.22%-аар, FTSE 100 индекс 2.28%-аар тус тус нэмэгдсэн байна.

Евро бүсийн бизнесийн үйл ажиллагааны өсөлт 7-р сард сүүлийн хоёр жилд байгаагүй өндөр хэмжээтэй байна. Үйлдвэрлэлийн болон үйлчилгээний гарцыг нэгтгэн тооцдог composite индекс 6 пунктээр өсөж, 54.9 болсон байна. Гэсэн хэдий ч, компаниуд бүрэн хүчин чадлаараа ажиллаагүйгээс гадна ажилчдаа цомхтгосоор байгаа юм.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд 7-р сарын сүүлээр огцом уналттай байсан боловч 8-р сарын эхний долоо хоногт өсөлт үзүүлсэн байна. Nikkei 225 индекс 620 пункт буюу 2.9%-аар өсөж 22,329.94 болсон нь өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 5.6%-аар бага байгаа юм. TOPIX индексүүд өсөлттэй байсан ба иений ханш харьцангуй тогтвортой арилжаалагдаж, Баасан гарагт 1 ам.доллар 106 иентэй тэнцэж байв.

БНХАУ: БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд эдийн засгийн нөхцөл байдал сайжирсантай холбоотойгоор долоо хоногийн турш өсөлттэй байлаа. Баасан гарагт Трампын засаг захиргаа АНУ дахь БНХАУ-ын TikTok болон WeChat зэрэг олон нийтийн сүлжээний компаниудад тавих хараа хяналтыг чангатгасан ч гэсэн CSI 300 large-cap индекс, Shanghai composite индекс аль аль нь өсөлттэй байсан байна. АНУ болон БНХАУ-ын технологийн маргаанаас үүдэн цахим хурлын Zoom компани БНХАУ-тай хийх шууд худалдааг зогсоож, зөвхөн гуравдагч талаар дамжуулан БНХАУ-тай түншлэх болсноо мэдэгджээ.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	16,403.43	-0.73% ▼
Dow Jones	АНУ	27,433.48	3.80% ▲
S&P 500	АНУ	3,351.28	2.45% ▲
Nasdaq	АНУ	11,010.98	2.47% ▲
S&P/TSX	Канад	16,544.48	2.32% ▲
FTSE 100	Их Британи	6,032.18	2.28% ▲
S&P/ASX 200	Австрали	6,004.80	1.30% ▲
Nikkei 225	Япон	22,329.94	2.86% ▲
Hang Seng	Хонг Конг	24,531.62	-0.26% ▼

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	111.43
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	102.57
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	101.59
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	104.63
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	100.71
DBM' 2023	USD	7.250%	103.30
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	96.33

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.163	0.05 ▲
Libor 3M	0.253	0.02 ▲
Libor 6M	0.309	0.01 ▲
Libor 1YR	0.449	0.00 ▲
US 2YR Bond	0.129	0.16 ▲
US 3YR Bond	0.141	0.13 ▲
US 5YR Bond	0.231	0.03 ▲
US 10YR Bond	0.564	0.02 ▲

Валютын ханш	2020.08.07	Өөрчлөлт
USD	2,846.32	0.06% ▲
CNY	408.89	0.29% ▲
EUR	3,370.33	-0.06% ▼
RUB	38.72	0.34% ▲
KRW	2.4	0.42% ▲
JPY	26.96	-0.81% ▼
CAD	2,133.67	0.63% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	2,035.55	3.02% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	28.30	16.04% ▲
Зэс	USD/lb.	279.25	-2.63% ▼
Нүүрс	USD/MT	56.27	6.03% ▲
WTI газрын тос	USD/bbl.	41.22	2.36% ▲
Brent газрын тос	USD/bbl.	44.40	2.54% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.24	24.44% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.VI	2.80%
Бодлогын хүү	2020.VI	9.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.VI	8.95%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.VI	10.98%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.VI	4.33%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.VI	17.03%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.VI	10.43%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 45 компанийн 444.0 сая төгрөгийн 1,031,280 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Стандарт агрикалчер групп” /MSE: SOH/ компанийн хувьцаа 9.09%-аар буюу хамгийн ихээр өсөж 60.00 төгрөг хүрч хаагдсан бол “Дархан нэхий” /MSE: NEH/ компанийн хувьцаа 29.80%-аар буурч 14.93 төгрөгт хүрч хаагдлаа.

Компанийн бондын хоёрдогч зах зээл дээр “Лэндмн ББСБ” ХК-ийн 21.4 сая төгрөгийн 214 ширхэг үнэт цаас арилжаалагдав

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

8-р сарын 7-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,514.4 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 16,403.43 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.73% -аар буурсан байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	LNBO-BD-19/06/21-C0008-17	214	21,396,000	100,000	98,000	52	17%

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	465.4	
Зах зээлийн үнэлгээ	2,514,411.0	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	16,403.43	-0.73% ▼
MSE I индекс	8,069.96	0.26% ▲
MSE II индекс	7,409.07	0.18% ▲

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Инвекор ББСБ	96,428	250,037,804
Эрдэнэ ресурс девелопмент корп	50,439	49,684,026
Говь	156,354	29,912,473
АПУ	43,339	23,977,151
Таван толгой	3,357	18,368,870

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Стандарт агрикалчер групп	60.00	9.09% ▲
УБ-БҮК	440.00	8.91% ▲
Ноёт хайрхан	363.00	6.76% ▲
Баянгол зочид буудал	32,800.00	5.80% ▲
Монгол нэхмэл	2,100.00	5.00% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Дархан нэхий	14.93	-29.80% ▼
Сор	650.00	-13.33% ▼
Дархан хөвөн	7,985.00	-13.20% ▼
Хөвсгөл алтандуулга	600.00	-13.04% ▼
БиДиСек	841.00	-11.47% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Инвекор Капитал	518,525,822
БиДиСек	89,421,543
Ти Ди Би Капитал	50,334,044
Стандарт Инвестмент	48,003,530
Эм Ай Би Жи	30,413,341

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	547.00	582,107.31
Таван толгой	5,500.00	289,658.60
МИК холдинг	12,990.00	269,014.07
Инвекор ББСБ	2,600.00	186,492.59
Говь	191.57	149,446.15

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.05.28-НД ОЛГОВ
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.29-НД ОЛГОВ
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН ББСБ	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НД ОЛГОВ
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.29-НД ОЛГОВ
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,404.8	1,000.0	29.4%	35.0	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.07.09-НД ОЛГОВ
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.07.30-НД ОЛГОВ
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.04.16-НД ОЛГОВ
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.07.03-НД ОЛГОВ
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.07.08-НД ОЛГОВ
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.04-НД ОЛГОВ
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.04.17-НД ОЛГОВ
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.07.31-НД ОЛГОВ
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.29-НД ОЛГОВ
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.07.21-НД ОЛГОВ
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



ОНЦЛОХ МЭДЭЭ

“Дархан нэхий” /MSE: NEH/ ХК-ийн хувьцааг хуваахтай холбоотой үйл ажиллагааг хийж дууссан тул Санхүүгийн зохицуулах хорооны Улсын байцаагчийн 99 тоот албан шаардлагын дагуу үнэт цаасны арилжааг 2020 оны 8-р сарын 6-ны өдрөөс эхлэн нээлээ.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“Улсын их дэлгүүр” /MSE: UID/ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд.

“Улсын их дэлгүүр” /MSE: UID/ ХК-ийн барилгад 2020 оны 6-р сарын 7-ны өдөр гал гарч барилгын зарим хэсэг шатсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газраас шалгалт, мөрдлөг хийсэн бөгөөд шинжээчдийн дүгнэлт гарсан байна.

Дүгнэлтээр “Тус барилга дээр дээврийн ажил хийж байсан ‘Ай Ти Эн’ ХХК-ийн ажилчид хар цаасыг халааж, хайлуулан наах ажил хийх явцдаа гал алдаж гал түймэр гарахад хүргэсэн” гэж тогтоосон байна. Уг хэрэгт Цагдаагийн Ерөнхий газрын Мөрдөн байцаах алба мөрдөн шалгах ажлыг үргэлжлүүлэн явуулж байгаа бөгөөд “Улсын их дэлгүүр” /MSE: UID/ ХК болон түрээслэгч нарын хохирлын хэмжээг тогтоохоор ажиллаж байна.

Галын аюулын улмаас “Улсын их дэлгүүр” /MSE: UID/ ХК-д ихээхэн хэмжээний хохирол учирсан бөгөөд энэхүү хохирлыг дотоод хүчин чадлаараа барагдуулан даван туулах боломж бололцоо хомс учраас “Номин Холдинг” ХХК болон түүний хамаарал бүхий компаниудаас ажиллах хүч, санхүүгийн туслалцаа авсны үр дүнд 2020 оны 7-р сарын 3-ны өдрөөс тус дэлгүүрийн 1 болон 2 давхрын засварын ажлыг гүйцэтгэн хэвийн ажиллагаанд оруулсан байна.

Түүнчлэн, “Улсын их дэлгүүр” /MSE: UID/ ХК нь үл хөдлөх хөрөнгийн даатгал, тус дэлгүүрт үйл ажиллагаа явуулж байсан түрээслэгч нар нь гэрээнд заасны дагуу бараа материалын даатгалд хамрагдсан болохыг “Улсын их дэлгүүр” /MSE: UID/ ХК-ийн зүгээс мэдэгдсэн байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Бодь даатгал” /MSE: BODI/ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд.

“Бодь даатгал” /MSE: BODI/ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 7-р сарын 24-ний өдрийн № 20/04 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 9-р сарын 09-ний өдрийн 11:00 цагт хуралдуулахаар болсон байна.

Хурлын тов: 2020 оны 9-р сарын 9-ний өдрийн 11:00 цагт.

Хуралдах газар: Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу, 14201, Novotel зочид буудал 4 давхрын хурлын танхимд

Бүртгэлийн өдөр: 2020 оны 8-р сарын 17-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

- 2020 оны хагас жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг тайлагнах;
- 2020 оны хоёрдугаар хагасын бизнес төлөвлөлтийг танилцуулах
- Компанийн “Дүрэм”-ийн төслийг батлах;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөв батлах.

Холбоо барих утас: 70110280

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“МИК холдинг” /MSE: MIK/ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд.

Монголбанкны 2020 оны 6-р сарын 23-ны өдрийн зөвшөөрлийн дагуу Худалдаа, хөгжлийн банкинд Улаанбаатар хотын банкныг нэгтгэн нийлүүлэх замаар өөрчлөн байгуулсантай холбогдуулан Улаанбаатар хотын банкны эзэмшил дэх “МИК холдинг” /MSE: MIK/ ХК-ийн нийт хувьцааны 10 хувь буюу 2,070,912 ширхэг хувьцааг Худалдаа, хөгжлийн банкинд шилжүүлсэн байна.

Энэхүү өөрчлөлтийн дагуу тус компанид эзлэх Худалдаа, хөгжлийн банкны эзэмшлийн хувь 19.99 хувь болж өөрчлөгдсөн байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ


ОНЦЛОХ МЭДЭЭ

БНХАУ болон Монгол улсын хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих зорилгоор Монголбанк, Хятадын Ардын Банкны хооронд байгуулсан 15 тэрбум юань буюу 6 их наяд төгрөгийн үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн гэрээг 2020 оны 7-р сарын 31-ний өдөр шинэчлэн байгуулж, своп хэлцлийг дахин 3 жилийн хугацаатайгаар сунгалаа.

Эх сурвалж: Монголбанк



МАКРО ЭДИЙН ЗАСАГ



Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 8-р сарын 7-ны өдрийн ээлжит бус хурлаар эдийн засгийн хүндрэлтэй нөхцлийн улмаас эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг 2020 оны 12-р сарын 31-ний өдрийг дуустал хэрэгжүүлэх шийдвэр гаргалаа.

Энэ нь Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 4-р сарын 13-ны өдрийн шийдвэрийн үргэлжлэл бөгөөд үүнийн хүрээнд нийт 76 мянга орчим зээлдэгчийн 663 тэрбум төгрөгийн хэрэглээний зээлийн нөхцөлд өөрчлөлт орсон байна. Цар тахалтай холбоотойгоор өрхийн хэрэглээнд үзүүлэх сөрөг нөлөө болон зээлдэгчийн санхүүгийн дарамтыг зөөлрүүлж, банкны системийн тогтвортой байдлыг ханган эдийн засгийн уналтыг сааруулахад дэмжлэг болж байна.

Хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

Эх сурвалж: Монголбанк

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Монголбанк 2020 оны 7 дугаар сард 2.2 тн үнэт металл худалдан авч, оны эхнээс өссөн дүнгээр нийт 13 тн үнэт металл худалдан аваад байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 5.5 тн-р өссөн үзүүлэлт юм. Монголбанкны нийт худалдан авсан 13 тн үнэт металлын 11.3 тн нь алт, 1.7 тн нь цагаан мөнгө байна.

2020 оны 7 дугаар сарын хувьд Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 81,7 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 169 кг үнэт металл худалдан аваад байна. Он гарснаас хойш орон нутаг дахь Монголбанкны 2 хэлтэс нийт 815.6 кг үнэт металл худалдан авлаа.

Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж үнэ 2020 оны 6 дугаар сард 167,504.44 төгрөг байлаа.

Эх сурвалж: Монголбанк



МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.